



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/12

Чойр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 21 дүгээр зүйлийн 21.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.2, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.1.2.6, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолын 02 дугаар хавсралын 2.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан "Хими, нян судлал, хорио цээрийн лабораторийг бэхжүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж"-ийг ашиглалтад хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ф.Болорцэцэг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Алтанцэцэг

(Орон нутгийн өмчийн газрын орон нутгийн өмч хариуцсан ахлах мэргэжилтэн)

Ц.Шагдаржав

(Мэргэжлийн хяналтын газрын хими, нян судлалын лабораторийн эрхлэгч)

/Зөвшилцсөнөөр/

О.Дөлгөөн

(Мэргэжлийн хяналтын газрын нягтлан бодогч)

/Зөвшилцсөнөөр/

Д.Нарангэрэл

(Синапс ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга:

Г.Энххишиг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2. Техник, тоног төхөөрөмжийг холбогдох хууль, тогтоомж, техникийн тодорхойлолтод заагдсан тоо хэмжээ, тавигдсан шаардлагын дагуу хүлээн авч, үр дүнг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Ф.Болорцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

